

ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ДОА-2025/039/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Чойбалсан хот

2025 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## **АГУУЛГА**

1. Хараат бус аудиторын дүгнэлт..... 3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....5-9
3. Аудитын илрүүлэлт .....10-11
4. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл.....11-12

## **ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ**

АДБОУС	Аудитын дээд байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг
НА	Нийцлийн аудит
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч

**1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ**



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

7 дугаар баг, Хэрлэн сум, Дорнод аймаг, 21000  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2025.02.04 № 268

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ДОРНОД АЙМГИЙН СЭРГЭЛЭН  
СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ДАРГА Д.ЭНХЖАРГАЛАН  
ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудал**

Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сумын Засаг даргаас 90.7 хувиар үнэлж дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

011022106

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ

**2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>235,012,898.21</b>	<b>260,264,906.21</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	159,705,927.00	164,723,351.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	62,609,927.00	67,627,351.00
35410	Бичиг хэргийн материал	3,329,375.00	2,871,975.00
35420	Аж ахуйн материал	30,777,002.00	32,667,002.00
35430	Сэлбэг хэрэгсэл	400,000.00	5,005,000.00
35440	Түлш, шатах тослох материал	715,936.00	60.00
35460	Хүнсний материал	29,000.00	-
35470	Бусад хангамжийн материал	27,358,614.00	27,083,314.00
35600	Мал амьтад	97,096,000.00	97,096,000.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	75,306,971.21	95,541,555.21
36300	Тэжээлийн нөөц	75,306,971.21	94,303,171.21
36400	Шатахууны нөөц	-	1,238,384.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,714,648,770.78</b>	<b>3,116,227,006.11</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,714,648,770.78	3,116,227,006.11
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,605,736,270.78	2,997,502,006.11
39201	Барилга, байгууламж, орон сууц	394,387,418.41	1,116,098,893.01
39202	Хуримтлагдсан элэгдэл	(80,912,599.46)	(99,592,757.78)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,480,095.00	147,380,095.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(36,070,780.74)	(39,484,996.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	208,593,060.00	267,985,360.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(142,776,168.38)	(153,257,288.69)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	84,997,319.20	84,035,657.20
39208	Хуримтлагдсан элэгдэл	(64,591,132.51)	(67,933,425.89)
39209	Зам, гүүрийн байгууламж	680,931,597.50	764,587,054.70
39210	Хуримтлагдсан элэгдэл	(135,773,396.64)	(201,322,195.92)
39214	Бусад үндсэн хөрөнгө	948,633,043.00	1,197,551,027.08
39215	Хуримтлагдсан элэгдэл	(292,162,184.60)	(358,671,026.96)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	-	340,125,611.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	108,912,500.00	118,725,000.00
39301	Програм хангамж	4,156,200.00	4,156,200.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,843,700.00)	(3,031,200.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	107,600,000.00	117,600,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,949,661,668.99</b>	<b>3,376,491,912.32</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,949,661,668.99</b>	<b>3,376,491,912.32</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,949,661,668.99	3,376,491,912.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	613,345,543.20	613,345,543.20
51101	Өмч: - төрийн	613,345,543.20	613,345,543.20
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	1,158,276,003.70	2,585,106,247.03
51210	Өмнөх үеийн үр дүн	920,442,239.11	1,158,276,003.70
51220	Тайлант үеийн үр дүн	237,833,764.59	1,426,830,243.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	178,040,122.09	178,040,122.09
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,949,661,668.99</b>	<b>3,376,491,912.32</b>

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,087,131,237.00</b>	<b>2,831,816,782.79</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>386,218,029.00</b>	<b>1,728,940,826.88</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	386,218,029.00	1,728,940,826.88
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,800.00	268,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	468,800.00	268,800.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	346,117,409.00	1,567,210,526.88
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	39,631,820.00	161,461,500.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,913,208.00</b>	<b>1,102,875,955.91</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,542,508.00	48,589,955.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,164,992.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,973,316.00	47,309,955.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,404,200.00	280,000.00
131107	Эрүүл мэндийн даатгалын сангийн нэмэлт орлого		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	640,370,700.00	1,054,286,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	523,370,600.00	1,054,286,000.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	117,000,100.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>849,297,472.41</b>	<b>1,255,164,189.46</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>814,792,572.41</b>	<b>1,199,732,975.46</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	772,883,890.66	1,061,672,058.81
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	422,161,730.83	677,371,779.04
210101	Үндсэн цалин	288,759,891.91	365,119,382.51
210102	Нэмэгдэл	111,855,102.92	278,357,129.53
210104	Урамшуулал	21,546,736.00	33,895,267.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	52,953,405.67	82,849,184.24
210201	Тэтгэврийн даатгал	36,143,818.67	56,635,641.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,876,960.51	6,692,695.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,097,924.17	17,104,447.25
210204	Ажилгүйдлийн даатгал	788,461.58	2,416,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,046,240.74	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,266,900.65	24,715,047.07
210301	Гэрэл, цахилгаан	4,382,335.65	3,494,437.07
210302	Түлш, халаалт	10,884,565.00	21,220,610.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	50,869,449.60	28,280,602.91
210401	Бичиг хэрэг	5,802,340.00	3,747,018.91
210402	Тээвэр, шатахуун	26,340,400.00	18,177,584.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,063,160.00	1,947,400.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,663,550.00	3,108,300.00
210408	Бараа материал акталсны зардал	-	1,300,300.00
210409	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн /ТӨҮГ/	12,999,999.60	-
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	210,000.00	-
210502	Хоол, хүнс	210,000.00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,620,000.00	5,533,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,090,000.00
210604	Урсгал засвар	7,620,000.00	4,443,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,292,992.00	15,189,500.00
210702	Дотоод албан томилолт	8,292,992.00	15,189,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,899,622.50	2,156,711.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	307,080.00	254,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,400.00	342,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,444.00	224,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	140,975.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,080,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	89,698.50	314,836.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	213,609,789.41	225,575,734.55
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	59,838,840.00	47,730,593.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	153,770,949.41	177,845,141.55

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	41,908,681.75	138,060,916.65
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,227,700.00	85,686,337.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,934,129.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	34,492,748.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,227,700.00	5,259,460.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	38,680,981.75	52,374,579.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,680,981.75	52,374,579.65
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>34,504,900.00</b>	<b>55,431,214.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	34,504,900.00	55,431,214.00
223001	Бусад хөрөнгө	34,504,900.00	55,431,214.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>237,833,764.59</b>	<b>1,576,652,593.33</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	149,822,350.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	10,462,050.00
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	139,360,300.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(149,822,350.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>237,833,764.59</b>	<b>1,426,830,243.33</b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>701,382,008.00</b>	<b>1,103,144,755.91</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>468,800.00</b>	<b>268,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	468,800.00	268,800.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	468,800.00	268,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	468,800.00	268,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>700,913,208.00</b>	<b>1,102,875,955.91</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	60,542,508.00	48,589,955.91
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,164,992.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,973,316.00	47,309,955.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	41,404,200.00	280,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	640,370,700.00	1,054,286,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	523,370,600.00	1,054,286,000.00
132004	Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/	117,000,100.00	-
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>636,887,408.40</b>	<b>1,027,895,541.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>636,887,408.40</b>	<b>1,027,895,541.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>594,978,726.65</b>	<b>889,834,625.26</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	421,877,256.32	677,371,779.04
210101	Үндсэн цалин	287,784,953.31	365,119,382.51
210102	Нэмэгдэл	112,545,567.01	278,357,129.53
210104	Урамшуулал	21,546,736.00	33,895,267.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	53,237,880.18	82,849,184.24
210201	Тэтгэврийн даатгал	36,143,818.67	56,635,641.40
210202	Тэтгэмжийн даатгал	4,876,960.51	6,692,695.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,382,398.68	17,104,447.25
210204	Ажилгүйдлийн даатгал	788,461.58	2,416,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	8,046,240.74	-
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	15,266,900.65	24,400,227.07
210301	Гэрэл, цахилгаан	4,382,335.65	3,494,437.07
210302	Түлш, халаалт	10,884,565.00	20,905,790.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	33,823,606.00	25,133,470.91
210401	Бичиг хэрэг	5,380,940.00	3,139,918.91
210402	Тээвэр, шатахуун	19,070,476.00	16,235,112.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,063,160.00	1,947,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	487,300.00	276,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,821,730.00	3,535,000.00

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	200,000.00	1,400,000.00
210502	Хоол, хүнс	200,000.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	8,821,805.00	11,053,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,608,405.00	5,304,900.00
210604	Урсгал засвар	7,213,400.00	5,748,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	8,292,992.00	15,189,500.00
210702	Дотоод албан томилолт	8,292,992.00	15,189,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,379,622.50	2,156,711.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	787,080.00	254,500.00
210803	Даатгалын үйлчилгээ	221,400.00	342,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	124,444.00	224,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	77,000.00	140,975.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,080,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	89,698.50	314,836.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	51,078,664.00	50,280,353.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	51,078,664.00	50,280,353.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>41,908,681.75</b>	<b>138,060,916.65</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,227,700.00	85,686,337.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	45,934,129.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	34,492,748.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,227,700.00	5,259,460.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	38,680,981.75	52,374,579.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	38,680,981.75	52,374,579.65
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>64,494,599.60</b>	<b>75,249,214.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>64,494,599.60</b>	<b>75,249,214.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>64,494,599.60</b>	<b>75,249,214.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	64,494,599.60	75,249,214.00
223001	Бусад хөрөнгө	59,074,599.60	75,249,214.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	5,420,000.00	-
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>(64,494,599.60)</b>	<b>(75,249,214.00)</b>
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	924,442,239.11	-	1,715,827,904.40
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	924,442,239.11	-	1,715,827,904.40
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	237,833,764.59	-	237,833,764.59
C08	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	1,162,276,003.70	-	1,953,661,668.99
D01	<b>2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	1,162,276,003.70	-	1,953,661,668.99
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	1,162,276,003.70	-	1,953,661,668.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,426,830,243.33	-	1,426,830,243.33
D09	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	613,345,543.20	178,040,122.09	2,589,106,247.03	-	3,380,491,912.32

Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1,056,311,000.00</b>	<b>1,002,180,220.35</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>996,895,000.00</b>	<b>926,931,006.35</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>915,398,800.00</b>	<b>845,954,129.35</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	684,012,400.00	677,371,779.04
210101	Үндсэн цалин	352,362,600.00	365,119,382.51
210102	Нэмэгдэл	293,269,400.00	278,357,129.53
210104	Урамшуулал	38,380,400.00	33,895,267.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	86,061,500.00	82,849,184.24
210201	Тэтгэврийн даатгал	57,920,700.00	56,635,641.40
210202	Тэтгэмжийн даатгал	6,769,500.00	6,692,695.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,954,900.00	17,104,447.25
210204	Ажилгүйдлийн даатгал	2,416,400.00	2,416,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	32,550,400.00	24,400,227.07
210301	Гэрэл, цахилгаан	6,772,400.00	3,494,437.07
210302	Түлш, халаалт	25,778,000.00	20,905,790.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	21,741,800.00	21,732,820.00
210401	Бичиг хэрэг	2,862,300.00	2,858,100.00
210402	Тээвэр, шатахуун	13,120,400.00	13,116,280.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,947,400.00	1,947,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	276,700.00	276,040.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,535,000.00	3,535,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1,401,400.00	1,400,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,401,400.00	1,400,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	13,082,200.00	11,053,400.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,157,200.00	5,304,900.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	661,300.00	-
210604	Урсгал засвар	5,263,700.00	5,748,500.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	14,765,500.00	14,739,500.00
210702	Дотоод албан томилолт	14,765,500.00	14,739,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,054,500.00	2,156,711.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,871,600.00	254,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	342,300.00	342,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	224,100.00	224,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	141,600.00	140,975.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,440,000.00	880,000.00
210807	Газрын төлбөр	314,900.00	314,836.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	55,729,100.00	10,250,508.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	55,729,100.00	10,250,508.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	81,496,200.00	80,976,877.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	81,496,200.00	80,976,877.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,451,900.00	45,934,129.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	34,493,000.00	34,492,748.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	551,300.00	550,000.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>59,416,000.00</b>	<b>75,249,214.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	59,416,000.00	75,249,214.00
223001	Бусад хөрөнгө	59,416,000.00	75,249,214.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1,056,311,000.00</b>	<b>1,002,180,220.35</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,055,711,000.00	1,001,911,420.35
132001	Орон нутгийн төсвөөс	1,055,711,000.00	1,001,911,420.35
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	600,000.00	268,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	600,000.00	268,800.00
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>28.00</b>	<b>25.00</b>
620001	Удирдах ажилтан	8.00	8.00
620002	Гүйцэтгэх ажилтан	16.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан		
620004	Гэрээт ажилтан	4.00	3.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>48,589,955.91</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>48,589,955.91</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	43,880,495.91
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	3,400,650.91
210401	Бичиг хэрэг	281,818.91
210402	Тээвэр, шатахуун	3,118,832.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	450,000.00
210702	Дотоод албан томилолт	450,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	40,029,845.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	40,029,845.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	4,709,460.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	4,709,460.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,709,460.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>48,589,955.91</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>48,589,955.91</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	47,309,955.91
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	280,000.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	<b>-</b>
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 706,720.3 мянган төгрөгийн 2 алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад залруулах бичилт хийлгэсэн.

*Залруулсан алдаа:*

- Байгууллагын Хүүхэд Эрдэнэ хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 1.1 сая төгрөгийн бараа материалыг бүртгэл тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"-ыг заавал тусгана, УСНББОУС -17, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлийг хангахгүй.
- Эрчим хүчний дулааны шугамын барилга, байгууламжийг 705.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд давхар бүртгэсэн байна.

Аудитаар нийт 533,654.2 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 550.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 533,104.2 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгч ажиллалаа.

### 3.1 Төлбөрийн акт

Төсвийн хөрөнгөөр 430.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл болон 120.0 мянган төгрөгийн 10 литр нэрмэл архи худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

худалдан авах"-ыг хориглосон заалт, 15.1.7 дахь "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглосон заалттай нийцэхгүй ба санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**3.2 Албан шаардлага**

1. Тус байгууллагын санхүү албаны дарга, 2 нягтлан, нярав нарт санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан гэх үндэслэлээр 6,020.0 мянган төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг давхардуулан олгосон байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1 дэх "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно", 15.1.3 дахь "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох" гэсэн заалтыг зөрчин Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор тогтоосон урамшууллын хэмжээг хэтрүүлэн олгосон, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих мэдээллээс 527,084.2 мянган төгрөгийн 10 мэдээллийн хугацааг хоцроосон байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн дагуу цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулахтай нийцэхгүй байна.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ". Харин зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Эрчим хүчний дулааны шугамын барилга, байгууламжийг хөрөнгийн бүртгэл тайланд давхар бүртгэсэн байна.	1	705,610.3	-	-	1	705,610.3	1	705,610.3	-	-	-	-
"Хүүхэд-Эрдэнэ" хөтөлбөрийн хүрээнд олгогдсон 1,110,000 төгрөгийн шүүгээ, дуу хураагуур, мэдээллийн самбар гэсэн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй байна.	1	1,110.0	1	1,110.0	-	-	1	1,110.0	-	-	-	-
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>706,720.3</b>	<b>1</b>	<b>1,110.0</b>	<b>1</b>	<b>705,610.3</b>	<b>2</b>	<b>706,720.3</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>

**Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл болон 10 литр нэрмэл архи худалдаж авсан	1	550.0	1	550.0									
Тус байгууллагын санхүү албаны дарга, 2 нягтлан, нярав нарт санхүүгийн тайлангийн аудитаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан гэх үндэслэлээр улирлын үр дүнгийн урамшууллыг хэтрүүлэн олгосон	1	6,020.0			1	6,020.0							
Шилэн дансны цахим хуудаст оруулбал зохих мэдээллээс 10 мэдээллийн хугацааг хоцроосон	1	527,084.2	-	-	1	527,084.2	-	-	-		-	-	
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>533,654.2</b>	<b>1</b>	<b>550.0</b>	<b>2</b>	<b>533,104.2</b>	-	-	-		-	-	



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  
АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 18 ДОА-2025/039/НА-СТА-ТМЗ Чойбалсан хот  
А4170629

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 болон 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсвийн хөрөнгөөр 430.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйл болон 120.0 мянган төгрөгийн 10 литр нэрмэл архи худалдан авсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.5 дахь "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах"-ыг хориглосон заалт, 15.1.7 дахь "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглосон заалтыг тус тус зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.8 дахь "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газар нь 550,000.0 /таван зуун тавин мянган/ төгрөгийг аймгийн Төрийн сан банкин дахь хүү торгуулийн орлогын 100070000952 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхжаргалан, нягтлан бодогч Б.Солонгозаяа нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АУДИТОР  Ч.УДВАЛНОРОВ



2125050053



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 51 ЗОА-2025/039/НА-СТА-ТМЗ  
АМ70629

Чойбалсан хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасны дагуу Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны цахим хуудаст төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – хөтөлбөр, зориулалт, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт-эдийн засгийн ангилал, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлттэй холбоотой 7, 9, 10, 11 дүгээр саруудын нийт 527.1 сая төгрөгийн 10 шийдвэрийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “Мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана. Үүнд:”, 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны цахим хуудаст хуульд заасан мэдээллийг хуулийн хугацаанд иж бүрэн мэдээлж байх, биелэлтийг 2025 оны 6 дугаар сарын 20-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Эрхжаргалан, нягтлан бодогч Б.Солонгозаяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

И.СЭМЖИДМАА

АУДИТОР

Ч.УДВАЛНОРОВ

2117144069  
ХТУ4337 9030891

2125040081



ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2025 оны 02 сарын 24 өдөр

Дугаар 50 ХОА-2025/039/НА-СТА-ТМЗ Чойбалсан хот

А 1170609

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Үйл ажиллагаа хариуцсан санхүүгийн албаны дарга, 2 нягтлан бодогч болон нярав нарт 1-1.5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 6,020.0 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан олгосон.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1. Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно: 15.1.3. хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр, тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох; Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2-д "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувьас хэтрэхгүй байна" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11 дэх "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Зөрчлийг давтан гаргахгүй байх, Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын дагуу урамшууллыг олгож байх, биелэлтийг 2025 оны 06 дугаар сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2125040077

2. Засгийн газрын тогтоол, шийдвэрийг баримтлан ажиллахыг Дорнод аймгийн Сэргэлэн сумын Засаг даргын Тамгын газрын дарга Д.Эрхжаргалан, нягтлан бодогч Б.Солонгозаяа нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН МЕНЕЖЕР  И.СЭМЖИДМАА

АУДИТОР  Ч.УДВАЛНОРОВ

